



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 115

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Орон нутгийн өмчийн газарт шаардлагатай нийт 13,380,000 /арван гурван сая гурван зуун наян мянга/ төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу бэлтгэж бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Ууганбаяр)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны ... дугаар сарын  
... өдрийн ... тогтоолын нэгдүгээр хавсралт

Орон нутгийн өмчийн газрын шинээр  
бэлтгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Делл процессор	ш	3	1,660,000	4,980,000
2	Делл дэлгэц	ш	3	460,000	1,380,000
3	Делл нөтбүүк	ш	1	1,600,000	1,600,000
4	Принтер Canon	ш	1	350,000	350,000
5	Тог баригч 1-тэй	ш	1	150,000	150,000
6	Тог баригч 2-той	ш	1	260,000	260,000
7	Баллонтой усны аппарат	ш	1	580,000	580,000
8	Баллонтой усны аппарат	ш	1	750,000	750,000
9	Халаагч конвектор	ш	1	220,000	220,000
10	Халаагч тенъ	ш	1	110,000	110,000
11	Лед самбар	ш	1	3,000,000	3,000,000
	Нийт дүн				13,380,000 /арван гурван сая гурван зуун наян мянга/